



НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 05 03

024

_____ оны _____ сарын _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

"Ар бадрах" ХХК-ийн гомдлын тухай

Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн хуралдааныг Б.Болормаа даргалж, гишүүд Д.Мөнхтуул, Х.Нямбаяр, Ё.Наранбилэг, Б.Төгслхам, нарийн бичгийн дарга Ж.Эрдэнэбүрэн нарын бүрэлдэхүүнтэй, "Ар бадрах" ХХК-аас Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 250013019 дугаар актад гаргасан гомдлыг, тус компанийн захирал Т.Эрдэнэбулган, Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ц.Зоригт нарыг оролцуулан магадлагч-татварын улсын байцаагч Б.Бадамцэцэг магадлагаа хийж, танилцуулснаар хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

1. "Ар бадрах" ХХК-ийн захирал Т.Эрдэнэбулган нь Татварын маргаан таслах зөвлөлд ирүүлсэн гомдолдоо: "Сүхбаатар дүүргийн татварын хэлтсээс манай байгууллагын 2016 оны 12 дугаар сарын 09 өдрөөс 2017 оны 05 дугаар сарын 31 өдөр хүртэлх хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хэсэгчилсэн шалгалт хийсэн.

Тус шалгалтаар Сүхбаатар дүүргийн Татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч Р.Долгорсүрэн, Д.Зоригт нар Татварын Ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.1.1, 18.1.14 заалтыг зөрчсөн зөрчилд 42,900,182.10 төгрөгийн нөхөн татвар ногдуулан төлүүлэхээр 2017 оны 05 дугаар сарын 31-ны өдөр 250013019 тоот акт тогтоосныг эс зөвшөөрч байна.

Иймд Татварын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6-д: "татварын албанаас гаргасан акт, дүгнэлт, бусад баримт бичигтэй танилцах, үндэслэлгүй буюу хуульд нийцээгүй гэж үзвэл танилцсанаас хойш 30 хоногийн дотор гомдлоо захиргааны болон шүүхийн журмаар гаргах" гэж заасны дагуу дараах гомдлыг гаргаж байна.

Манай компани нь анхан шатны баримтыг үндэслэн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг бичигдсэн огноо, дугаар, компанийн нэр, барааны үнэ, төлсөн татварын дүнг тухайн тайлант үеүдэд татварын тайландаа худалдан авалтаар тусгаж тайлангаа тушаасныг Татварын алба, татварын улсын байцаагч баталгаажуулан авч байсан. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль батлагдан 2015 оны 8 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн мөрдөгдсөн бөгөөд 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх хугацаанд тухайн төрлийн албан татвар төлөгчөөр татварын албанд бүртгүүлсэн, санхүү татварын тайлангаа гаргасан байвал зохих хувь хүн, хуулийн этгээд ийнхүү бүртгүүлээгүй, мэдүүлээгүй, тайлагнаагүй боловч энэ хуульд заасан хугацаанд сайн дурын үндсэн дээр шинээр тайлагнасан бол нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Татварын ерөнхий хуульд заасан албан татвар болон орлогоо

нуун дарагдуулсны улмаас хүлээх хариуцлагаас нэг удаа чөлөөлөхөөр заасан бөгөөд хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх хувь хүн, хуулийн этгээдэд ийнхүү чөлөөлөгдөхөөр заасан үндэслэлээр дахин эрүүгийн хэрэг үүсгэх, захиргааны хариуцлага хүлээлгэх, гүйцэтгэх ажил явуулах, холбогдох мэдээлэл, санхүүгийн болон албан татварын тайланд тусгасан албан татвар ногдох орлого, орлогоос бусад албан татвар ногдох зүйл, тэдгээрийн эх үүсвэр, хэмжээ, үнэ өртгийг нууцлах бөгөөд нотлох баримт болгон ашиглахыг хориглохоор хуульчилсан.

Энэ хуулийн хүрээнд татвар ногдох орлогоо нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан, санхүүгийн тайланд сайн дурын үндсэн дээр хуулийн хугацаанд мэдүүлсэн.

Иймд татварын улсын байцаагчийн 2017 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 25001309 тоот акттай холбоотой гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэж хүчингүй болгож өгнө үү" гэж тэмдэглэсэн.

2. Татварын улсын байцаагч Ц.Зоригт ирүүлсэн тайлбартаа: "Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч Р.Долгорсүрэн, Ц.Зоригт бид татварын хяналт шалгалт хийх удирдамж, томилолтын дагуу "Ар бадрах" ХХК-ийн 2010-2012 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж 42,900,182.10 төгрөгийн төлбөр ногдуулсан. Тус компани "Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай" хуулийн дагуу нэмэгдсэн өртгийн албан татварын, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын төрлөөр тус тус тайлан гаргасан байсан. Тухайн үед Татварын ерөнхий газраас нэмэгдсэн өртгийн албан татварын падаантай холбоотой зөрчил бол акт үйлдэх хэрэгтэй гэсэн чиглэлтэй байсан тул төлбөр ногдуулсан" гэж тэмдэглэсэн.

3. Магадлагч-татварын улсын байцаагч Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 6 дугаар зүйлд заасан эрх, үүргийн дагуу оролцогч талуудаас ирүүлсэн гомдол, тайлбар, татварын болон санхүүгийн тайлан, анхан шатны баримт, журналын бүртгэл зэрэг холбогдох материалд тулгуурлан Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйл болон бусад хууль тогтоомжид үндэслэн магадлагаа хийж, татварын улсын 250013019 дугаар актыг бүхэлд нь хүчингүй болгох гэсэн саналыг оруулсан.

ҮНДЭСЛЭХ НЬ:

"Ар бадрах" ХХК-ийн 2010-2012 оны албан татварын ногдуулалт төлөлтийн байдалд Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ц.Зоригт, Р.Долгорсүрэн нар шалгалт хийж, татварын улсын байцаагчийн 250013019 дугаар актаар 1 төрлийн 429,001,820.8 төгрөгийн зөрчил илрүүлж 42,900,182.1 төгрөгийн нөхөн татвар, 0 төгрөгийн торгууль, 0 төгрөгийн алданги бүгд 42,900,182.1 төгрөгийн төлбөр ногдуулсныг эс зөвшөөрч гомдол гаргасан. Үүнд:

2721511 тоот регистр, 2006 оны 12 сарын 20-ны өдрийн хуулийн этгээдийн бүртгэлийн 9011046113 тоот гэрчилгээтэй "Ар бадрах" ХХК-ийн 2010-2012 оны албан татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж татварын улсын байцаагчийн актаар нийт 429,001,820.80 төгрөгийн зөрчил нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дах заалтыг зөрчсөн гэж үзэн 42,900,182.10 төгрөгийн нөхөн татвар ногдуулсныг зөвшөөрөөгүй гомдол гаргасан байна.

Татварын улсын байцаагчийн 250013019 тоот актад дурдагдсан зөрчлийн талаар ил тодын тайланд тайлагнахаас өмнө уг зөрчилтэй холбоотойгоор татварын албанаас акт, дүгнэлт гаргаж байгаагүй болно.

Иймд Засгийн Газрын 2015 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 348 дугаар тогтоолоор баталсан Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх

журмын 2 дугаар зүйлийн 2.1.1-д «нуун дарагдуулсан» гэж хувь хүн, хуулийн этгээд хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 4.1-д заасны дагуу 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө мэдүүлэх, бүртгүүлэх, тайлагнах үүргээ биелүүлээгүйн улмаас холбогдох албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, дутуу төлсөн байхыг ойлгох бөгөөд энэ нь холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны аливаа хяналт шалгалтаар тогтоогдоогүй байхыг», мөн журмын 4 дүгээр зүйлийн 4.1.1-д «татвар төлөгчөөр бүртгүүлээгүй, эсхүл татварын тайлан гаргаагүй буюу буруу гаргасан бол шинэчилсэн тайланг харьяалах татварын албанд мэдүүлэх» гэсэн заалтуудыг зөрчөөгүй байна.

"Ар бадрах" ХХК нь Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д «Албан татвар ногдох орлого, орлогоос бусад албан татвар ногдох зүйл, нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогыг 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх хугацаанд нуун дарагдуулсан боловч энэ хуулийн 3.1-д заасан хугацаанд сайн дурын үндсэн дээр ил болгож, санхүүгийн болон албан татварын, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг шинээр гаргаж харьяалах татварын алба, нийгмийн даатгалын байгууллагад сайн дурын үндсэн дээр мэдүүлсэн бол тухайн хувь хүн, хуулийн этгээдийг энэ хуулийн 4.1-д заасан хуульд заасан хариуцлагаас нэг удаа чөлөөлнө» гэж заасны дагуу санхүүгийн болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын нэмж мэдүүлсэн тайлан гаргасан байна.

Татварын улсын байцаагчийн 250013019 тоот актаар 2012 онд "Далайдорж", "Хүслэнт хулан" ХХК-аас хайрга зөөх ажилд хэрэглэсэн шатахуун худалдан авч нийт 429,001,820.80 төгрөгийн падаан бичүүлэн тайландаа худалдан авалтаар тусгаж нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах орлого бууруулсан зөрчилд 42,900,182.10 төгрөгийн нөхөн татвар ногдуулсан нь Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д «Энэ хуулийн 4.1-д заасны дагуу харьяалах гааль, татварын алба, харилцагч санхүүгийн байгууллагад сайн дурын үндсэн дээр шинээр гаргаж өгсөн санхүүгийн болон татварын тайлан, гаалийн байгууллагад нөхөн мэдүүлсэн барааны мэдүүлгийг тухайн хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны эхлэлтийн тайлан, баланс, мэдүүлэг гэж тус тус үзэх бөгөөд эдгээр тайлан, мэдүүлэгт сайн дурын үндсэн дээр мэдүүлж шинээр тусгасан албан татвар ногдох орлого, орлогоос бусад албан татвар ногдох зүйлд албан татвар, хүү, торгууль, алданги нөхөн ногдуулахгүй» гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д «Энэ хуулийн 4.1, 5.1-д заасны дагуу хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх хувь хүн, хуулийн этгээдэд ийнхүү чөлөөлөгдөхөөр заасан үндэслэлээр дахин эрүүгийн хэрэг үүсгэх, захиргааны хариуцлага хүлээлгэх, гүйцэтгэх ажил явуулахыг хориглоно» гэсэн заалтыг үндэслэн татварын улсын байцаагчийн 250013019 тоот актыг хүчингүй болгох нь зүйтэй байна гэж зөвлөлийн бүрэлдэхүүн дүгнэлээ.


Татварын ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 7 дахь заалтыг удирдлага болгон

ТОГТООХ НЬ:

1. Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.3, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /2006 оны/ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, "Анхны ардчилсан сонгууль болж, байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 10 дугаар зүйлийн 10.7, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 6 дугаар зүйл 6.1 дэх заалтыг үндэслэн татварын улсын байцаагчийн 250013019 дугаар актаар 429,001,820.8 төгрөгийн зөрчил илрүүлж 42,900,182.1 төгрөгийн нөхөн татвар, 0 төгрөгийн торгууль, 0 төгрөгийн алданги бүгд 42,900,182.1 төгрөгийн төлбөр ногдуулсныг бүхэлд нь хүчингүй болгосугай.

2. Шийдвэрийг эс зөвшөөрвөл актад гомдол гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дээд шатны татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөл болон Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ХУРАЛ ДАРГАЛСАН:



Б.БОЛОРМАА

ГИШҮҮД :



Д.МӨНХТУУЛ




Х.НЯМБАЯР



Е.НАРАНБИЛЭГ



Б. ТӨГСЛХАМ



Ж. ЭРДЭНЭБҮРЭН